АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цахир сумын засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2024/11-НА-СТА-ТТЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Архангай аймаг<br>2023 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Ахлах аудитор Н.Алтантуяа<br>Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.03.25 № 171

танай ____________-ны №____________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦАХИР СУМЫН ЗАСАГ ДАРГА Д.ГАЛБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Цахир сумын засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Цахир сумын засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

МУЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу тус орлогыг тайлант оноос захиран зарцуулж, тайлагнах болсон байна

### Бусад асуудлын хэсэг

Сумын засаг дарга нь 2023 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 127 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 88.4 хувьтай үнэлсэн байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.
Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.
Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.
Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 769,490.5 | 862,429.0 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 372,020.4 | 479,366.0 |
| 33 | АВЛАГА | 228,270.4 | 255,362.2 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 135,586.2 | 95,664.3 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 33,613.5 | 32,036.4 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,674,994.6 | 2,153,524.4 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,674,994.6 | 2,153,524.4 |
| 39200 | Биет хөрөнгө | 1,441,554.3 | 1,919,896.8 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 233,440.3 | 233,627.6 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 2,444,485.1 | 3,015,953.3 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 12,600.0 | 17,507.5 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 12,600.0 | 17,507.5 |
| 41300 | Өглөг | 12,600.0 | 17,507.5 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,431,885.1 | 2,998,445.8 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,431,885.1 | 2,998,445.8 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 446,645.9 | 446,645.9 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 1,876,765.1 | 2,443,325.8 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 108,474.2 | 108,474.2 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 2,444,485.1 | 3,015,953.3 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */ мянган төгрөгөөр /*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,367,948.1 | 2,074,248.8 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 348,536.5 | 420,658.4 |
| 110 | Орлогын албан татвар | 164,188.9 | 209,081.8 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 164,182.6 | 209,055.6 |
| 1102 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 6.3 | 26.2 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 59,251.8 | 68,449.0 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 125,095.8 | 143,127.6 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 367,655.9 | 785,794.4 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 367,655.9 | 785,794.4 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,651,755.7 | 867,796.0 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,245,454.8 | 1,124,391.8 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,245,454.8 | 1,124,391.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 952,316.7 | 1,119,391.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 328,549.2 | 456,806.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 41,475.1 | 55,196.4 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 99,087.8 | 30,113.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 46,399.1 | 78,382.6 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,434.2 | 500.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,071.0 | 13,215.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 58,030.7 | 182,572.3 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 368,269.7 | 302,606.4 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,293,138.1 | 5,000.0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 122,493.3 | 949,857.1 |

| | | | |
|---|---|---|---|
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 2,773,881.4 | 383,296.4 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | -2,651,388.1 | 566,560.7 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 2,206,758.1 | 1,510,053.1 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 348,536.5 | 420,658.4 |
| 110 | Орлогын албан татвар | 164,188.9 | 209,081.8 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 164,182.6 | 209,055.6 |
| 1102 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 6.3 | 26.2 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 59,251.8 | 68,449.0 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 125,095.8 | 143,127.6 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 5,519.7 | 6,322.6 |
| 1181 | Газрын төлбөр | 28,882.3 | 27,227.7 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 90,693.9 | 109,577.4 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 206,465.9 | 221,598.7 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 206,465.9 | 221,598.7 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,651,755.7 | 867,796.0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,893,316.9 | 894,180.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,893,316.9 | 894,180.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 782,162.4 | 889,180.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 328,549.2 | 455,068.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 41,475.1 | 56,934.3 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 99,087.8 | 30,113.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 47,214.6 | 76,224.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,574.2 | 500.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,071.0 | 13,215.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 144,402.4 | 195,059.2 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 110,788.2 | 62,066.4 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,111,154.4 | 5,000.0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 313,441.2 | 615,873.2 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 267,873.2 | 438,527.5 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 267,873.2 | 438,527.5 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 267,873.2 | 438,527.5 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -267,873.2 | -438,527.5 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -165,000.0 | -70,000.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 165,000.0 | 70,000.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | -119,432.0 | 107,345.6 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 491,452.4 | 372,020.4 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 372,020.4 | 479,366.0 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 5,132,185.6 | 5,132,185.6 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -48,912.3 | -48,912.3 |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 5,083,273.3 | 5,083,273.3 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.0 | 0.0 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.0 | 0.0 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.0 | 0.0 |
| 7 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.0 | 0.0 |
| 8 | Зарласан ногдол ашиг | 0.0 | 0.0 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | -2,651,388.1 | -2,651,388.1 |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,431,885.1 | 2,431,885.1 |
| 11 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 2,431,885.1 | 2,431,885.1 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.0 | 0.0 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,431,885.1 | 2,431,885.1 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.0 | 0.0 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.0 | 0.0 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.0 | 0.0 |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.0 | 0.0 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0.0 | 0.0 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 566,560.7 | 566,560.7 |
| 20 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,998,445.8 | 2,998,445.8 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,572,737.9 | 1,400,665.1 | 172,072.8 | 89.1 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,058,520.0 | 957,368.7 | 101,151.3 | 90.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,053,520.0 | 952,368.7 | 101,151.3 | 90.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 457,397.2 | 455,068.1 | 2,329.1 | 99.5 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 57,174.7 | 56,934.3 | 240.4 | 99.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 152,966.6 | 128,684.5 | 24,282.1 | 84.1 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 75,977.8 | 75,816.0 | 161.8 | 99.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 34,150.0 | 33,087.9 | 1,062.1 | 96.9 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 15,960.0 | 13,215.0 | 2,745.0 | 82.8 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 116,642.4 | 73,094.1 | 43,548.3 | 62.7 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 143,251.3 | 116,468.8 | 26,782.5 | 81.3 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,000.0 | 5,000.0 | - | 100.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,000.0 | 5,000.0 | - | 100.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 411,372.3 | 373,296.4 | 38,075.9 | 90.7 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 102,845.6 | 70,000.0 | 32,845.6 | 68.1 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,572,737.9 | 1,315,314.4 | 257,423.5 | 83.6 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,064,895.7 | 1,097,058.7 | (32,163.0) | 103.0 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 507,842.2 | 218,255.7 | 289,586.5 | 43.0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 158,052.5 | (158,052.5) | #DIV/0! |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 72,701.8 | (72,701.8) | #DIV/0! |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 8 | 8 | | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 28 | 28 | | 100.0 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 28 | 28 | | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,042.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,042.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,042.4 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 408.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 934.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 700.0 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,042.4 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,042.4 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд алдаа[1] илрээгүй. Аудитаар залруулагдаагүй нийт 10,869.3 мянган төгрөгийн зөрчил[2] илэрч, 1 зөвлөмж хүргүүллээ. Энэхүү илэрсэн зөрчил нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон гүйцэтгэлийн материаллаг байдал 17,693.3 мянган төгрөгөөс доогуур байгаа тул Зөрчилгүй дүгнэлт хүргүүлэв.

### 5.1 Зөвлөмж

*5.1.1 Зээлийн авлагатай холбоотой асуудал*

***Илрүүлэлт:*** Хоршоо хөгжүүлэх сангаас 2022 онд зээл авсан 1 аж ахуй нэгж, 4 иргэний 2023 онд төлөх үндсэн төлбөр 9,847.5 мянган төгрөг, хүүгийн төлбөр 1,021.8 мянган төгрөг, нийт 10,869.3 мянган төгрөгийн тайлант хугацаанд хамаарах хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох,сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 10 дугаар зүйлийн 10.1-т “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина.”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна” гэсэн заалтыг зөрчиж байна.

***Зөвлөмж:*** *Хугацаа хэтэрсэн зээлийг зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төвлөрүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах*

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, холбогдох нотлох баримтын хамт 2024 оны 12 дугаар сарын 05-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,
[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Зээл төлүүлэх холбогдох арга хэмжээг аваагүй | 1 | 10869.3 | | | | | 1 | 10869.3 | 0 | 0 | 0 | 0 |